

Маргааны товч:

Том татвар төлөгчийн газрын Татварын хяналт шалгалтын улсын байцаагч нараас “Баян их үйлс” ХХК-ийн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацааны Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, төсөвт төлсөн татварын дүн, Ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шалгалт хийж, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн НА-21220000080 дугаартай нөхөн ногдуулалтын акт тавьжээ.

Татварын ерөнхий газрын дэргэхэд Татварын маргаан таслах зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 15 дугаар тогтоолоор дээрх нөхөн ногдуулалтын актаар тавьсан төлбөрийг бууруулж шийдвэрлэсэн байна.

Нэхэмжлэгчээс “тооцооллын алдаатай акт гаргасан, хуулийг буруу тайлбарлан хэрэглэж, хууль үйлчлэх хугацааг буруу тодорхойлсон” зэргээр нөхөн ногдуулалтын актын үлдэх дүнтэй маргажээ.